



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2026/101/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Аудитын менежер: Утас: 70523020 Аудитор:	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn У.Оюунтүлхүүр Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Б.Ариунбаатар Цахим хаяг: ariunbaatarb@audit.gov.mn
---	---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
5.1 Аудитын залруулга	9
5.2 Албан шаардлага.....	9
6.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Хараат бус аудиторын дүгнэлт



Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2026.02.25 № 1-6/09
танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Ц.БАТСУГИР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дорноговь аймгийн ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын захирамжаар туршлага судлуулах хөтөлбөрийг баталж нэр бүхий 21 төлөөлөгчийн тойрогтоо ажиллах зардлаас 104.6 сая төгрөгийг Вьетнам улсад аялах зардалд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор батлагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журмын 3.5-д "Төлөөлөгчийг чадавхжуулах арга хэмжээг Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага болон холбогдох сургалтын чиглэлээр мэргэшсэн сургалтын бусад байгууллага, судлаачдын багтай хамтран зохион байгуулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 19 төлөөлөгч тойрогтоо ажиллах зардлаас 49.8 сая төгрөгийг спортын тэмцээн уралдаан болон тэмээний баяр, хурдан морины уралдаан гэх мэт зардалд зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" заасантай нийцэхгүй байна.

Аудитын гол асуудал

Аймгийн ИТХ-ын даргын захирамжаар 35 төлөөлөгчийн үйл ажиллагаа болон чадавхжуулах зардлыг Засгийн газрын 2021 оны 402 тогтоолоор батлагдсан "Иргэдийн

442505049

төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам"-д 5,000,000 төгрөг байхаар тусгасан хэдий ч 1 төлөөлөгч дунджаар 12.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг баримталж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор батлагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журмын хавсралтад "аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч үйл ажиллагаа болон чадавхжуулах зардлын жишиг хэмжээ 5.0 сая төгрөг байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд бусад асуудлын хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Төгрөгөөр Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	31,563,160.85	41,534,587.05
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	63,802.00	7,460,314.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	63,802.00	7,460,314.00
3121	Төгрөг	63,802.00	7,460,314.00
31212	Монгол банкин дахь харилцах	63,802.00	7,460,314.00
33	АВЛАГА	184,938.66	1,164,350.86
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	149,938.66	790,750.13
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	350,000.00
335	Бусад авлага	35,000.00	23,600.73
3351	Байгууллагаас авах авлага	35,000.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	23,600.73
35	БАРАА МАТЕРИАЛ	31,314,420.19	32,909,922.19
354	Хангамжийн материал	31,314,420.19	32,909,922.19
35410	Бичиг хэргийн материал	2,011,300.00	2,191,350.00
35420	Аж ахуйн материал	22,514,320.19	21,918,972.19
35430	Сэлбэг хэрэгсэл	6,020,600.00	5,439,600.00
35440	Түлш, шатах тослох материал	768,200.00	-
35470	Бусад хангамжийн материал	-	3,360,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	91,710,052.46	567,137,229.92
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	91,710,052.46	567,137,229.92
392	Биет хөрөнгө	91,710,052.46	567,137,229.92
39201	Барилга, байгууламж, орон сууц	-	11,994,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,199,400.00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	257,000,000.00	411,150,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(215,000,000.03)	(14,000,000.07)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	66,106,424.00	186,648,824.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(29,656,286.78)	(41,949,714.95)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	45,897,567.24	51,685,567.24
39208	Хуримтлагдсан элэгдэл	(32,637,651.97)	(37,192,046.30)
393	Биет бус хөрөнгө	-	-
39301	Програм хангамж	20,561,528.79	20,561,528.79
39302	Хуримтлагдсан элэгдэл	(20,561,528.79)	(20,561,528.79)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,120,000.00	1,120,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,120,000.00)	(1,120,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	123,273,213.31	608,671,816.97
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,786,440.76	10,303,047.99
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,786,440.76	10,303,047.99
413	Өглөг	2,786,440.76	10,303,047.99
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,786,440.76	958,077.99
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	40,000.00
4136	Бусад өглөг	-	9,304,970.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	9,064,970.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	240,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	120,486,772.55	598,368,768.98
51	Засгийн газрын хувь оролцоо	120,486,772.55	598,368,768.98
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	68,719,077.67	68,719,077.67
51101	Өмч: - төрийн	68,719,077.67	68,719,077.67
512	Хуримтлагдсан үр дүн	51,423,034.70	529,305,031.13
51210	Өмнөх үеийн үр дүн	51,423,034.70	51,423,034.70
51220	Тайлант үеийн үр дүн	-	477,881,996.43
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	344,660.18	344,660.18
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	123,273,213.31	608,671,816.97

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төгрөгөөр Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,335,955,657.15	3,079,622,642.79
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	365,020,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	365,020,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	365,020,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	365,020,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,335,955,657.15	2,714,602,642.79
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	200,000,000.00	915,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	40,000,000.00	915,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,135,955,657.15	2,713,687,642.79
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,135,955,657.15	2,713,687,642.79
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,347,956,110.28	2,601,740,646.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,347,956,110.28	2,601,740,646.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,335,878,770.28	2,583,549,646.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	496,319,250.26	572,512,985.15
210101	Үндсэн цалин	256,520,851.09	223,279,222.89
210102	Нэмэгдэл	194,519,438.04	281,586,493.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,557,070.77	28,261,931.34
210104	Урамшуулал	15,721,890.36	39,385,337.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,873,158.90	71,018,116.33
210201	Тэтгэврийн даатгал	41,920,964.00	48,593,851.22
210202	Тэтгэмжийн даатгал	4,738,100.00	5,668,009.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,790,394.90	2,866,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	947,600.00	2,853,578.14
210205	Эрүүл мэндийн даатгал	9,476,100.00	11,036,277.75
2104	Хангамж, бараа материалын зардал	45,934,783.00	50,385,812.72
210401	Бичиг хэрэг	2,674,000.00	5,407,000.00
210402	Тээвэр, шатахуун	32,809,250.00	32,267,696.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,222,180.00	5,793,559.22
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,085,353.00	6,917,557.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,414,000.00	22,835,298.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	99,990.00
210604	Урсгал засвар	16,414,000.00	22,735,308.00
2107	Томилолт, зочны зардал	9,697,700.00	19,783,839.00
210702	Дотоод албан томилолт	9,697,700.00	11,270,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	8,513,839.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,647,291,088.10	1,787,691,823.62
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,642,044,294.10	1,782,733,445.62
210803	Даатгалын үйлчилгээ	4,556,794.00	4,310,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	154,378.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,348,790.02	59,321,771.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,107,721.96	7,273,856.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,299,053.64	26,000,693.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,942,014.42	26,047,222.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,077,340.00	18,191,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,077,340.00	18,101,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,077,340.00	18,101,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	90,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	90,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(12,000,453.13)	477,881,996.43
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	20,000.02	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	20,000.02	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(20,000.02)	-

5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(12,020,453.15)	477,881,996.43
---	-------------------------	-----------------	----------------

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төгрөгөөр Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,335,955,657.15	2,727,227,754.79
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	12,590,112.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	12,590,112.00
120009	Бусад орлого	-	12,590,112.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,335,955,657.15	2,714,637,642.79
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	200,000,000.00	950,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	40,000,000.00	950,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,135,955,657.15	2,713,687,642.79
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,135,955,657.15	2,713,687,642.79
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,338,924,854.15	2,583,376,842.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,338,924,854.15	2,583,376,842.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,326,668,714.15	2,564,835,842.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	492,640,169.41	586,957,570.71
210101	Үндсэн цалин	226,228,711.09	227,693,801.75
210102	Нэмэгдэл	213,431,497.19	290,491,879.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,377,070.77	28,261,931.34
210104	Урамшуулал	23,602,890.36	40,509,957.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,353,800.00	71,396,765.11
210201	Тэтгэврийн даатгал	41,401,600.00	48,972,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,738,100.00	5,668,009.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,790,400.00	2,866,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	947,600.00	2,853,578.14
210205	Эрүүл мэндийн даатгал	9,476,100.00	11,036,277.75
2104	Хангамж, бараа материалын зардал	45,811,033.00	51,066,512.72
210401	Бичиг хэрэг	2,784,300.00	4,613,000.00
210402	Тээвэр, шатахуун	32,690,000.00	31,499,496.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,181,380.00	8,368,559.22
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,011,353.00	6,585,457.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,136,340.00	17,677,530.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,640,000.00	839,990.00
210604	Урсгал засвар	17,496,340.00	16,837,540.00
2107	Томилолт, зочны зардал	9,697,700.00	18,977,839.00
210702	Дотоод албан томилолт	9,697,700.00	11,230,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	7,747,839.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,652,196,768.10	1,780,739,251.25
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,646,949,974.10	1,775,750,823.25
210803	Даатгалын үйлчилгээ	4,556,794.00	4,310,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	154,378.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	480,050.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,832,903.64	38,020,374.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,211,300.00	9,574,284.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,621,603.64	28,446,090.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,256,140.00	18,541,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,256,140.00	18,101,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,256,140.00	18,101,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	440,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	440,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(2,969,197.00)	143,850,912.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	136,454,400.00

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		-	136,454,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр		-	136,454,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал			136,454,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		-	(136,454,400.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		(2,969,197.00)	7,396,512.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			63,802.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		63,802.00	7,460,314.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Төгрөгөөр
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	68,719,077.67	350,489.06	21,123,061.00	90,192,627.73
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	68,719,077.67	344,660.18	21,123,061.00	90,186,798.85
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	30,299,973.70	30,299,973.70
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	68,719,077.67	344,660.18	51,423,034.70	120,486,772.55
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	68,719,077.67	344,660.18	51,423,034.70	120,486,772.55
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	68,719,077.67	344,660.18	51,423,034.70	120,486,772.55
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	477,881,996.43	477,881,996.43
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	68,719,077.67	344,660.18	529,305,031.13	598,368,768.98

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,795,849,900.00	2,718,791,242.79	77,058,657.21	97.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,795,849,900.00	2,718,791,242.79	77,058,657.21	97.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,776,649,900.00	2,701,290,242.79	75,359,657.21	97.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	588,104,600.00	586,957,570.71	1,147,029.29	99.8
210101	Үндсэн цалин	235,046,200.00	227,693,801.75	7,352,398.25	96.9
210102	Нэмэгдэл	283,300,500.00	290,491,879.77	(7,191,379.77)	102.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,583,500.00	28,261,931.34	2,321,568.66	92.4
210104	Урамшуулал	39,174,400.00	40,509,957.85	(1,335,557.85)	103.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,903,600.00	71,396,765.11	506,834.89	99.3
210201	Тэтгэврийн даатгал	48,972,500.00	48,972,500.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,732,700.00	5,668,009.22	64,690.78	98.9

**Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан**

210203	ҮОМШӨ-ний даатгал	2,866,400.00	2,866,400.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,866,400.00	2,853,578.14	12,821.86	99.6
210205	Эрүүл мэндийн даатгал	11,465,600.00	11,036,277.75	429,322.25	96.3
2104	Хангамж, бараа материалын зардал	69,666,500.00	51,066,512.72	18,599,987.28	73.3
210401	Бичиг хэрэг	7,786,800.00	4,613,000.00	3,173,800.00	59.2
210402	Тээвэр, шатахуун	43,500,000.00	31,499,496.00	12,000,504.00	72.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,199,700.00	8,368,559.22	(168,859.22)	102.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	-	180,000.00	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,000,000.00	6,585,457.50	3,414,542.50	65.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	167,500,000.00	154,131,930.00	13,368,070.00	92.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	144,500,000.00	839,990.00	143,660,010.00	0.6
210604	Урсгал засвар	23,000,000.00	153,291,940.00	(130,291,940.00)	666.5
2107	Томилолт, зочны зардал	24,730,000.00	18,977,839.00	5,752,161.00	76.7
210702	Дотоод албан томилолт	14,230,000.00	11,230,000.00	3,000,000.00	78.9
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	10,500,000.00	7,747,839.00	2,752,161.00	73.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,802,030,000.00	1,780,739,251.25	21,290,748.75	98.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,796,010,000.00	1,775,750,823.25	20,259,176.75	98.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	-	350,000.00	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	4,800,000.00	4,310,000.00	490,000.00	89.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000.00	154,378.00	95,622.00	61.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,000.00	44,000.00	76,000.00	36.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	480,050.00	19,950.00	96.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,715,200.00	38,020,374.00	14,694,826.00	72.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,715,200.00	9,574,284.00	2,140,916.00	81.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	41,000,000.00	28,446,090.00	12,553,910.00	69.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,200,000.00	17,501,000.00	1,699,000.00	91.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,200,000.00	17,501,000.00	1,699,000.00	91.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,200,000.00	17,501,000.00	1,699,000.00	91.2
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,795,849,900.00	2,726,277,754.79	69,572,145.21	97.5
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,795,849,900.00	2,713,687,642.79	82,162,257.21	97.1
132001	Орон нутгийн төсвөөс	2,795,849,900.00	2,713,687,642.79	82,162,257.21	97.1
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	12,590,112.00	-12,590,112.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	12,590,112.00	-12,590,112.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	63,802.00	(63,802.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	7,460,314.00	(7,460,314.00)	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

			төгрөгөөр
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	950,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	950,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	950,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		600,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	350,000.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		350,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	950,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	950,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		600,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		350,000.00

5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 167,694.4 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, аудитын явцад 13,335.5 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 154,358.9 мянган төгрөгийн 3 албан шаардлага өгсөн.

5.1 Аудитын залруулга

1. Завсрын аудитаар Ахмадын санд шилжүүлсэн 11,465.5 мянган төгрөгийг үр дүнгийн тайлангийн цалингийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.
2. Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан 1,870.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн орлогыг шилжиж ирсэн мөнгөн орлогоор бүртгэсэн байна.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 154,358.9 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 126,830.8 мянган төгрөгөөр их байх тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.2 Албан шаардлага

Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

1. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр Дорноговь аймгийн ИТХ-ын төлөөлөгчид Вьетнамд аялах зардалд 139.0 сая төгрөг зарцуулжээ гэсэн мэдээллийн дагуу шалгахад Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нэр бүхий 24 төлөөлөгч, 21 төлөөлөгчийн тойрогтоо ажиллах зардлаас 104.6 сая төгрөгийг Вьетнам улсын хотуудаар аялах зардалд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор батлагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журмын 3.5-д “Төлөөлөгчийг чадавхжуулах арга хэмжээг Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага болон холбогдох сургалтын чиглэлээр мэргэшсэн сургалтын бусад байгууллага, судлаачдын багтай хамтран зохион байгуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

2. Аймгийн ИТХ-ын 19 төлөөлөгч тойрогтоо ажиллах зардлаас 49.8 сая төгрөгийг спортын тэмцээн уралдаан болон тэмээний баяр, хурдан морины уралдаан гэх мэт зардалд зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д *“байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах”* заасантай нийцэхгүй байна.

3. Аймгийн ИТХ-ын даргын захирамжаар 35 төлөөлөгчийн үйл ажиллагаа болон чадавхжуулах зардлыг Засгийн газрын 2021 оны 402 тогтоолоор батлагдсан "Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам"-д 5,000,000 төгрөг байхаар тусгасан хэдий ч 1 төлөөлөгч дунджаар 12.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг баримталж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор батлагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журмын хавсралтад *“аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч үйл ажиллагаа болон чадавхжуулах зардлын жишиг хэмжээ 5.0 сая төгрөг байна”* гэж заасантай нийцэхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн зардлаас ахмадын санд шилжүүлсэн мөнгийг зардлаар тайлагнаагүй	1	11,465.5	1	11,465.5	-	-	1	11,465.5	-	-
Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг мөнгөн орлогоор бүртгэсэн	1	1,870.0	-	-	1	1,870.0	1	1,870.0	-	-
Дүн	2	13,335.5	1	11,465.5	1	1,870.0	2	13,335.5	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ИТХ-ын чадавхжуулах аялалын зардал зарцуулсан	1	104,580.0			1	104,580.0	-	-	-	-
ИТХ-ын төлөөлөгчийн үйл ажиллагаа болон чадавхжуулах зардлыг журмын дагуу зарцуулаагүй	1	-			1	-				
Дүн	2	104,580.0	-	-	2	104,580.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр/)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж Уралдаан тэмцээн санхүүжүүлсэн	1	49,778.9	-	-	1	49,778.9	-	-	-	-
Дүн	1	49,778.9	-	-	1	49,778.9	-	-	-	-
Нийт дүн	3	154,358.9	-	-	2	154,358.9	-	-	-	-